



Сургалт судалгаа

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ СУДАЛГААНЫ АЖИЛ ХИЙХ АРГА ЗҮЙН ТАЙЛБАР ЗӨВЛӨМЖ

Монгол улсын Боловсролын тухай хуулинд зааснаар багш бэлтгэх сургууль болон их дээд сургуулиудын аль аль нь нэг талаараа эрдэм шинжилгээний байгууллага болдог. Өнөөдөр манай их дээд сургуулийн багш оюутнуудын эрдэм шинжилгээний ажлын хүрээнд нэг сэдэвт бүтээл, магистрын болон бакалаврын судалгааны ажлууд зонхилох байр суурийг эзэлж байна. Судалгааны ажил хийх арга зүйг "Боловсрол судлал" хичээлийн агуулгад багтаан зөвхөн багш бэлтгэдэг их дээд сургуулийн хичээлийн төлөвлөгөөнд тусгагдсанаас манай сонсогч оюутнууд "Курсын ажил", "Дипломын ажил" хийх арга зүйг эзэмшээгүйгээс судалгааны ажилд хойрго хандаж, зөвхөн онолын судалгааг хийж байна гэж ном хуулах явдал хавтгайрч байна. Эрдэм шинжилгээ судалгааны ажил хийх арга зүйн талаар 1978 оны стандарт зөвлөмжийг эс тооцвол одоогоор нийтэд хэрэглэгдэж байгаа зөвлөмж алга байна. Иймээс Хилийн Цэргийн Сургуулийн сонсогчдод тус дөхөм болгох зорилгоор магистрын болон бакалаврын дипломын ажил бичих аргачилсан зөвлөмжийг бичин толилуулж байна.

Цэргийн сургуулийн сонсогчдын судалгааны ажлын сэдэв нь:

1. Тухайн салбарын өмнө тулгарсан онолын болон практикийн бодит бэрхшээлийг гэтлэн давах,
2. Албаны болон тусгай онцлогийг илрүүлэн гаргах,
3. Тодорхой асуудлыг шийдвэрлэх

гэсэн гурван хэлбэрээр эрдэм шинжилгээний нэг том сэдвийн хүрээнд сонсогчид тодорхой сэдэв авч судлах ёстой. Судалгааны ажил хийхдээ тухайн судлагч нэг талаас мэдлэг мэдээллийн хүч бололцоондоо тохируулан, нөгөө талаас судалгааны ажлын үр дүн нь практикт нийцэхүйц байхыг бодолцож сэдвийг сонгох явдал туйлын чухал юм. Өнөөдөрийн манай их дээд сургуулийн практикаас үзвэл оюутан сонсогчдын дипломын болон магистрын ажлын сэдэв нь суралцах хугацааныхаа турш цуглуулсан мэдлэг чадвар дадлагын хуримтлал болдог учраас сонирхсон асуудлынхаа талаар реферат,

курсын ажил бичих, илтгэл тавих зэргээр дэлгэрүүлэн хөгжүүлсээр эцэст нь боловсролын зэрэг хамгаалахуйц хэмжээний бүтээл болговол зохино.

Сэдвээ сонгон авсаны дараа объектоо тогтоох бөгөөд судалгааны ажлын объектив болон субъектив мэдлэгийн системүүд, судалгаанд бодитоор оролцох биетүүд үүнд багтана. Жишээлбэл: "Цэргийн сургалтын зохион байгуулалтын хэлбэрийг судлах нь" гэсэн сэдвээр судалгааны ажил хийж байгаа бол түүний **объект нь сургалтыг зохион байгуулж байгаа хамт олон, цэрэг дайчид, сургалтын зохион байгуулалтын хэлбэрийн талаархи онолын болон практикийн мэдлэгийн систем болно.**

Объектоо тодорхойлсны дараагаар судалгааны ажлын зорилгоо тодорхойлох бөгөөд тэр нь товч тодорхой асуудлаа бүрэн шийдвэрлэсэн байх нь зүйтэй. Тухайлбал дээрх судалгааны ажлын зорилгыг:

"Цэргийн сургалтын зохион байгуулалтын хэлбэрийг өнөөгийн сургалтын системтэй уялдуулан, сургалтын үйл ажиллагаанд зохион байгуулалтын ямар хэлбэрийг ашиглавал сурган хүмүүжүүлэх үйл явц нь үр дүнтэй байх, тогтвортой найдвартай харилцааг тогтоох, сургалтын зохион байгуулалтын хамгийн ашигтай хэлбэрийг илрүүлэн гаргахад оршино" гэж тодорхойлж болох юм.

Зорилгоосоо зорилтоо дэвшүүлнэ. Зорилт гэдэг маань зорилгыг хэрэгжүүлэхийн тулд ойрын хугацаанд хэрэгжүүлэх ажил юм. Тухайлбал дээрх сэдвийн хүрээнд:

- Цэргийн сургуулийн сургалтын зохион байгуулалтын хэлбэрийг бусад их дээд сургуулийн сургалтын зохион байгуулалтын хэлбэртэй харьцуулан судлах
- Одоогийн сургалтын зохион байгуулалтын хэлбэрийн ашигтай ба ашиггүй талыг илрүүлэх
- Сургалтын зохион байгуулалтын хамгийн үр өгөөжтэй шинэлэг аргуудыг тодорхойлох

гэх мэтээр судлах сэдвийнхээ хүрээнээс халилгүйгээр ажлынхаа бүтцийг тодорхойлно гэсэн үг юм.

Зорилго, зорилтоо тодорхойлсны дараагаар судалгаа шинжилгээний аргаа тодорхойлно. СХУ-нд судалгаа шинжилгээний аргыг гурван бүлэг арга болгон тодорхойлжээ.

1. Онолын судалгааны арга / Баримт бичгүүдэд судалгаа хийх, эх зохиол ном сурах бичигтэй ажиллах, архивын судалгааны арга гэх.мэт/

2. Практик судалгааны арга /Ажиглалтын, харилцан ярилцах, анкет судалгааны, лаборатори туршилтын, тестийн арга гэх мэт/
3. Математик статистикийн арга /компьютерийн болон мэдээлэл зүйн, өгөгдөхүүний тусламжтайгаар тооцоолон гаргах /

Эдгээр гурван аргаас судалгааны ажлынхаа онцлогийг харгалзан аргуудаа сонгон авч хэрэглэнэ.

Үүний дараагаар судалгааны ажлаа хийх дэлгэрэнгүй төлөвлөгөө гарган ажлаа эхэлнэ.

Судалгааны ажлын материал буюу бүтээл маань **Оршилоор** эхэлж байх учиртай.

Оршилд судлагаа явуулах болсон үндэслэл, судалгааны объект, зорилго, зорилт, судалгааны арга, үе шат, судалгааны таамаглал, судалгааны ажлын бүтэц зэрэг орно. Судалгаа явуулах болсон үндэслэлд ямар учраас энэ талаар судлах болсон тухайгаа, таны өмнө уг асуудлыг ямар хүмүүс хэрхэн судалсан, судалж шийдвэрлээгүй орхисон асуудал, эсвэл огт судлагдаагүй эсэхийг заавал судалсан байх шаардлагатай. Та судалгаагаа хийх явцдаа энэ талаар судалсан эрдэмтэн судлаачдын бүтээлтэй танилцсан байх ёстой. Харин судалгааны үе шат гэдэгт таны судалгаа хэдэн үе шаттай явагдах тухайгаа бичнэ. Таамаглалд энэ судалгааны ажлыг явуулсаны үр дүнд практикт яаж хэрэгжүүлснээр ямар ахиц гарах, онолын болон практикийн ямар ач холбогдолтой болох зэргийг зорилго судалгааны ажлынхаа үе шат зэргээс хамааран таамаглал дэвшүүлэн бичсэн байх шаардлагатай. Таамаглал бичсэний дараагаар дипломынхоо ажлын бүтцийн талаар тодорхой бичнэ. Тухайлбал **"миний энэ ажил нь оршил . . . бүлэг, . . . зүйл, дүгнэлт, ном зүй гэсэн . . . хэсгээс бүрдэнэ"** гээд дараа нь бүлэг тус бүрийн онцлогийн талаар товчхон бичвэл зүйтэй.

Судалгааны ажлын маань үндсэн хэсэг буюу судалгааны болон онолын материалын хэсэг гэдгийн талаар товч дурдъяа. Үүнд:

1. Таны судалж байгаа шинжлэх ухаанд сонгож авсан сэдвийг юу гэж үздэг, үүнийг хэн хэн судалж онолын болон практикийн ямар ямар үзэл баримтлалуудыг дэвшүүлсэн, эдгээр үзэл баримтлалууд нь амьдралд хэрхэн хэрэгжиж байдаг гэх мэтээр зөвхөн онолын судалгааны ажлууд зонхилвол зүйтэй юм.

2. Практик судалгааны ажлын тайлангаа бичих хэрэгтэй. Тухайлбал хилийн цэргийн анги салбар дээр судалгааны ямар арга хэрэглэн хичнээн цэргийн албан хаагчдаас ямар судалгаа авсан,хууль

хяналтын ямар байгууллага дээр ямар материал судалгаатай танилцсан, гэх мэтээр бодитоор хийгдсэн судалгааны ажлаа маш дэлгэрэнгүй бичнэ. Энэ судалгааны ажлаа дэлгэрэнгүйгээр бичсэний дараагаар дүгнэлт бичих зайлшгүй шаардлагатай.

3. Таны судалж байгаа асуудал өнөөгийн амьдралд яаж нийцэж байна. Одоо зайлшгүй шийдвэрлэвэл зохих асуудал нь юу вэ гэдгээ онолын үндэслэлийг нь сайн гаргаж өгсөн байх шаардлагатай.

4. Энэ асуудлыг шийдвэрлэх, үүнийг яаж сайжруулах талаар таамаглал дэвшүүлж санал онолоо бичнэ. Мөн санаагаа туршиж нотолсон практик туршилтын ажлууд байвал сайн. Өөрөөр хэлбэл энэ бүлэгт таны шинжлэх ухаанд оруулж буй хувь нэмэр бичигдэнэ гэсэн үг юм.

5. Дүгнэлт хэсэгт төлөвлөгөөний дагуу судалгааныхаа үр дүнг дүгнэнэ. Үүнд:

- Шинэ санал
- Практикт хэрэглэх арга зам
- Цаашид үргэлжлүүлэн судалж болох гэсэн гурван асуудлыг товчхон бичсэн байх хэрэгтэй.

6. Судалгааны ажилд багтах хавсралт материал /хүснэгт, бүдүүвч, судалгааны материал, зураг гэх мэт) - уудыг цэгцлэн хавсаргасан байвал зохино.

Ном зүйг бичих талаар хэдэн үг бичье. Юуны өмнө та судалгааны материалынхаа бүтцийг анхаарч үзэх ёстой. Жишээ нь: Хууль тогтоомж, дүрэм журам, ном сурах бичиг, сонин сэтгүүл гэх мэтчилэн ангилах учиртай. Дараа нь тус тусад нь бичихдээ ямар хэл дээр бичсэн зүйл ашигласан байдлаар нь мөн ангилах ёстой. Хамгийн чухал анхаарах зүйл бол ашигласан материалаа зохиогчийн нэрсийн цагаан толгойн үсгийн дарааллаар жагсааж бичнэ гэдгээ мартаж болохгүй.

Онолын хувьд судалгааны үр дүнг илтгэл, реферат, курсын ажил, бакалаврын болон магистрын дипломын ажил, диссертаци, нэг сэдэвт зохиолын хэлбэрээр гаргасан байх ёстой.

Эрдэм шинжилгээ судалгааны ажил хийх логик дараалал нь ийм байна. Гэхдээ энэ дараалалд бүгд баригдана гэсэн ойлголт байж бас болохгүй.

Ямарч тохиолдолд дараахь шаардлагуудыг хангасан байх шаардлагатай. Үүнд:

1. Юуны өмнө зорилгоо тодорхойлж ажиллах.
2. Ном зохиолыг ул суурьтай судалж бичиж тэмдэглэх
3. Амьдрал практикт тохиолдож буй үзэгдэл юмсыг

- соргоогоор ажиглаж төрсөн шинэ санаагаа тэмдэглэж байх
4. Уншсан, ажигласан зүйл дээрээ тулгуурлан ургуулан бодож, хийсвэрээр сэтгэн төлөвлөж сурах
 5. Эрдэм шинжилгээний чимхлүүр ажлыг залхуурахгүйгээр хийж сурах, толь бичиг хөтлөх, ноорог хийх, дахин тэмдэглэх, каталоги хийх, гэх мэт.
 6. Ажлын дэглэмээ тогтоож, эр зоригтой ажиллах шаардлаг *i*.

Зөвхөн судлаач оюутан та бүхний бүтээлч оролдлого, оюуны цар хүрээ, танин мэдэхүйн болон практик үйл ажиллагааны туршлага, уйгагүй идэвхитэй ажиллагааны үр дүнд л таны судалгааны ажлын үр дүн харагдаж, та өөрөө түүнийхээ хэрээр хөгжиж боловсрох болно.

Эцэст нь хэлэхэд эрдэмтэн судлаачид, удирдагч, шүүмжлэгч, зөвлөгч багш нартайгаа үргэлж хамтран ажиллаж тэдний туршлагаас байнга суралцах нь хэзээ ч хэний ч бичсэн заавар зөвлөгөөнөөс дутахгүй гэдгийг сануулахад илүүдэхгүй биз ээ.

Таны судалгааны ажил тань бүтэмжтэй, үйлс тань өөдрөг байх болтугай.

*ХЦС-ийн ЭШТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан,
Боловсрол судлалын магистр А. Туяа*

